



МОНГОЛ УЛСЫН 2018-2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД 2019 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ЗТХЯ-ны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээ/

2020.01.10

Улаанбаатар хот

**Нэг. Хяналт-шинжилгээний зорилго, үндэслэл, арга зүй**

Хяналт-шинжилгээ хийх зорилго нь Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн зорилтыг хангахад чиглэгдсэн арга хэмжээний гүйцэтгэлийн явцын талаар дүгнэлт гаргаж, холбогдох байгууллага, албан тушаалтанд бодит мэдээлэл өгсний үндсэн дээр тусгагдсан арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлэх зохион байгуулалт, зохицуулалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Эрх зүйн үндэслэл нь Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоол болно. /Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолоор тус хөтөлбөрийг тодотгон баталсан./ Энэ тогтоолын заалтын дагуу хэрэгжүүлсэн ажлын явцад хийсэн хяналт-шинжилгээний тайлан, тусгагдсан арга хэмжээний биелэлтийн хамт Үндэсний хөгжлийн газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх ба энэ нь Засгийн газраас тус яамны үйл ажиллагааг үнэлж дүгнэх нэг шалгуур үзүүлэлт болохын зэрэгцээ яамны ерөнхий менежер, нэгжийн менежерүүдийн үйл ажиллагаа, үр дүнгийн гэрээний биелэлтийн түвшинг үнэлж, дүгнэх нэг үзүүлэлт болох ач холбогдолтой.

Арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн түвшингийн хувийг тогтоохдоо Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ыг баримталсан болно. Хөтөлбөрт Зам, тээврийн хөгжлийн сайдын хэрэгжүүлэх 24 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

**Хоёр. Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн байдал**


Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан Зам, тээврийн хөгжлийн сайдын шилжин хэрэгжих 18, шинээр хэрэгжүүлэх 6 арга хэмжээг 2019 оны жилийн эцсийн байдлаар үнэллээ. Шилжин хэрэгжүүлэх арга хэмжээ 92%, шинээр хэрэгжүүлэх арга хэмжээ 90%, нийт арга хэмжээний хэрэгжилт **дунджаар 91.4%-тай** байна.

Нийт арга хэмжээг салбар тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 1

Төмөр зам	Авто зам	Агаарын тээвэр	Автотээвэр	Логистик, бодлого
3	16	2	1	2
85% Үнэлэх боломжгүй-1	91.4% Үнэлэх боломжгүй-2	100%	100%	85%

Зураг 1




Нийт арга хэмжээг хэрэгжилтийн хувиар үзүүлбэл:

Хүснэгт 2

100%	70%	40%	Үнэлэх боломжгүй
16	4	1	3

Зураг 2



### Гурав. Дүгнэлт

1. Зам, тээврийн хөгжлийн сайдын хэрэгжүүлэх 24 арга хэмжээний хэрэгжилтийг авч үзвэл 2019 оны жилийн эцсийн байдлаар үр дүнтэй буюу 100 хувийн хэрэгжилттэй 16, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувийн хэрэгжилттэй 4, эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувийн хэрэгжилттэй 1, үнэлэх боломжгүй 3 арга хэмжээ байна.

2. Дараах шалтгааны улмаас 3 арга хэмжээг үнэлэх боломжгүй гэж үзлээ. Үүнд:

Хүснэгт 3

№	Арга хэмжээ	Хэрэгжээгүй шалтгаан
1	<p>Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 45.3 км төмөр замын төсөл</p> <p>Төслийн ажлын явц 40 хувь.</p> <p>Барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.</p>	<p><b>2018 он:</b> Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын шугамын чигийг ЗГ-ын 2017 оны 126 дугаар тогтоолоор батлуулсан.</p> <p>БНХАУ-ын Зураг төслийн 3 дугаар хүрээлэн боловсруулсан Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, зураг төслийг “МАК” ХХК “Мөнгөн зөрлөг” ХХК-тай 2017 оны 05 дугаар сард гэрээ байгуулан шинэчлүүлсэн.</p> <p>Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын геологи, геодези, археологи, палентологийн судалгаанууд болон Техникийн зураг төслийг боловсруулсан.</p> <p>“МАК” ХХК, “Өсөх зоос” ХХК, “Өмнийн говийн элс” ХХК, “Чинхуа МАК Нарийнсухайт” ХХК нар хамтран “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-ийг байгуулсан.</p> <p>“Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтын төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын 2018.08.01-ний өдрийн 232 тоот тогтоолоор “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-тай хамтарсан төрийн өмчийн тавин нэгээс доошгүй хувийн оролцоотой “Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийг хууль тогтоомжийн дагуу байгуулахыг даалгасан.</p> <p>Тогтоолыг хэрэгжүүлэхээр “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-тай Төслийн хамтарсан “Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийг байгуулахаар, компанийн хувьцаа эзэмшигчдийн гэрээний төслийг боловсруулсан. Уг боомтын төмөр замыг 2019 онд ашиглалтад оруулах зорилгоор ажлын нарийвчилсан төлөвлөгөө гарган Дэд сайдаар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>ЗГ-ын 2018.10.24-ний өдрийн хуралдаанаар тус чиглэлийн төмөр замын царигийн өргөний хэмжээг Улсын Их Хурлын 2014 оны “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” 64 дүгээр тогтоолын 1 дэх заалтад нэмэлт оруулахыг дэмжиж, 44 дүгээр тэмдэглэл гарч УИХ-аар хэлэлцэхээр хүлээгдэж байна.</p> <p><b>2019 он:</b> Тус чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх асуудал нь “Ар Ди Си Си” ХХК-ийн барьж байгуулсан Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн хатуу хучилттай авто замын “барих-ашиглах-шилжүүлэх” концессын гэрээний холбогдох зүйл, заалттай зөрчилдөн шүүх байгууллагад шалгагдаж байгаагаас төмөр замын ажил зогсонги байдалтай байна.</p> <p>Тус чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг бүрэн боловсруулж дууссан бөгөөд царигийн өргөний хэмжээг УИХ-аар тогтоосны дараа барилгын ажлыг эхлүүлнэ. Цариг шийдвэрлэгдээгүй үед барилгын ажил эхлүүлэх боломжгүй тухай хөрөнгө оруулагч талаас албан ёсоор мэдэгдээд байна. УИХ-ын 2019 оны Хаврын чуулганаар 2014 оны 64 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцүүлэх явцад тус төслийн ТЭЗҮ, тооцоо судалгааг дахин нягтлах гэсэн шалтгаанаар Засгийн газрын 2019.05.12-ны өдрийн 21 дүгээр тэмдэглэл гарч буцаан татсан. Засгийн газрын 2018 оны 232 дугаар тогтоолоор Шивээхүрэн-Сэхэ боомт хооронд 13 км төмөр зам барих тухай шийдвэр гарсан хэдий ч тухайн <b>төмөр замын царигийн өргөний хэмжээ тодорхойгүйгээс барилгын ажил эхлүүлэх боломжгүй байна.</b></p>
2	<p>Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км цемент бетон хучилттай их даацын авто зам</p> <p>Төслийн ажлын явц 20 хувь.</p> <p>Төслийг хэрэгжүүлэгчтэй гэрээ байгуулан, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэнэ.</p>	<p><b>2018 он:</b> Концессын “зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхээр ЗГ-ын 2017.06.14-ний өдрийн 166 дугаар тогтоолоор Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад нэмж тусгасан. Уг тогтоолын дагуу УХГ-аас 2017.08.16-ны өдөр “Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км цемент бетон хучилттай их даацын авто зам төсөл”-ийн концесс олгох 2 үе шаттай уралдаант шалгаруулалтыг зарласан. Урьдчилсан шалгаруулалтад оролцох саналыг 2017.10.16-ны өдрийн 11.00 цаг хүртэл хүлээн авсан бөгөөд тус төсөлд 1 оролцогч санал ирүүлсэн бөгөөд комисс уг оролцогчийн саналыг үнэлж, дараагийн үе шат болох уралдаант шалгаруулалтад оруулахаар шийдвэрлэсэн.</p> <p>Комиссоос уралдаант шалгаруулалтын баримт бичиг боловсруулан тус оролцогчид 2018.01.16-ны өдөр баримт бичгийг олгож эхэлсэн бөгөөд төслийн саналыг 2018.04.19-ний өдрийн 11.00 цагт нээсэн боловч нэг ч санал ирээгүй болно.</p> <p><b>2019 он:</b> Уралдаант шалгаруулалтад шаардлага хангасан төслийн санал ирээгүй тул концессын тухай хуулийн дагуу шууд гэрээ байгуулах нөхцөл бүрдсэн. Үндэсний хөгжлийн газраас концесс эзэмшигчийг сонгон шалгаруулах шууд гэрээний урилгыг 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хүлээн авахаар 2019.08.30-ны өдөр цахим хуудсандаа байршуулсан боловч <b>санал ирээгүй</b>. Иймд тус төслийг цаашид концессоор хэрэгжүүлэхэд дахин төслийн санал ирүүлэх магадлал бага байгаа тул хөрөнгө оруулалтын өөр хэлбэрээр хэрэгжүүлэх боломжийг судлаж үзэхийг хүссэн 01/3163 дугаартай албан тоотыг Үндэсний хөгжлийн газраас тус яаманд ирүүлсэн.</p>
3	<p>Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 143 км авто зам</p> <p>Төслийн ажлын явц 100 хувь.</p> <p>Үлдэгдэл санхүүжилт бүрэн шийдвэрлүүлж, төслийг бүрэн дуусгана.</p>	<p>2017 онд тус авто замыг Улсын байнгын ашиглалтад оруулсан. Үлдэгдэл санхүүжилт 2019 оны төсөвт тусгагдсан бөгөөд баталгаат засварын хугацаанд улсын комиссоос өгөгдсөн үүрэг даалгаврыг биелүүлэн төсөвт тусгагдсан эцсийн гүйцэтгэлээ авах байсан боловч <b>гүйцэтгэгч ажлаа хийж гүйцэтгээгүй</b>. Тухайн ажлыг хийж гүйцэтгэсний дараа улсын төсөвт тусгуулан санхүүжих боломжтой.</p>

3. 40 хувийн биелэлттэй дараах 1 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэллээ. Үүнд:

Хүснэгт 4

№	Арга хэмжээ	Хэрэгжилт
1	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто замын төсөл  Төслийн ажлын явц 30 хувь. Барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.	<p><b>2018 он:</b> ТЭЗҮ-ийг боловсруулах санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй. Тус төслийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах зорилгоор 2018.03.22-23-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Монголын эрдэс баялаг-Уул уурхай-2018” хөрөнгө оруулалтын чуулга уулзалтад танилцуулсан.</p> <p>Засгийн газрын 2018.05.23-ны өдрийн 139 дүгээр тогтоолоор Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих төслийг “Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхээр Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад “Шууд гэрээ байгуулах”-аар тусгасан. Мөн ЗГ-ын 2018.05.23-ны 153 дугаар тогтоолоор “Зүүнбаян төмөр зам” ХХК-тай Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг концессын “Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр барьж байгуулах хэлэлцээ хийж, гэрээний төслийг ЗГ-ын хуралдаанд танилцуулахыг Үндэсний хөгжлийн газарт даалгасан. Иймээс уг төмөр замтай зэрэгцүүлэн хүнд даацын цементбетон хучилттай 500 км авто зам барих нь эдийн засгийн хувьд ашиггүй гэж үзсэн. Харин эхний ээлжид Тавантолгойн нүүрсийг экспортлох шинэ гарц бий болгох, коксжих нүүрсээ Бугатын төмрийн үйлдвэр буюу эцсийн хэрэглэгчид шууд хүргэх боломжтой Тавантолгой-Ханги чиглэлийн хүнд даацын авто замын төслийг хэрэгжүүлэх нь улс орны эдийн засагт үр өгөөжөө өгөхөөс гадна замын барилгын ажилд зарцуулсан хөрөнгө оруулалтаа зам ашигласны хураамжаас нөхөх боломжтой. Оюутолгой болон бусад замын дагуух уурхайнууд уг замын төслийг дэмжиж байна гэдгээ илэрхийлээд байгаа.</p> <p><b>2019 он:</b> Засгийн газрын 2018.10.31-ний өдрийн 329 дүгээр тогтоолоор “Тал нутгийн хөгжлийн зам” ХХК-тай гэрээ байгуулах зөвшөөрлийг Үндэсний хөгжлийн газарт олгосны дагуу 2019.03.29-ны өдөр концессын гэрээ байгуулсан. Концесс эзэмшигчийн зүгээс гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөлүүдийг ханган, холбогдох материалыг Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн бөгөөд 2019 оны 12 дугаар сард эрх бүхий этгээдээс гэрээ хүчин төгөлдөр болсныг баталгаажуулсан.</p>

### Дөрөв. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж

Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тодорхойлсон бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд тэргүүлэх ач холбогдол өгч, улсын санхүүжилтийг жил бүрийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусгуулж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газарт;

2. Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тодорхойлсон бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх нийт арга хэмжээнүүдийн хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар 91.4%-тай, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто замын төслийн хэрэгжилт 40%-тай, Тяньжин тээвэр логистикийн төв байгуулах төсөл, Бүс нутгийн автозамыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл, Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, 63 км авто замын ажил 70%-тай байгааг анхаарч, хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээг эрчимтэй авч, 2020-2021 онд хүрэх түвшин, үр дүн, шалгуур үзүүлэлтэд хүргэхэд анхаарч ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар, Авто замын хэрэгжилтийг зохицуулах газар, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, “Монголын төмөр зам” ТӨХК, “Улаанбаатар төмөр зам” ХНН, “Тавантолгой төмөр зам” ХХК -уудад тус тус зөвлөж байна.



Танилцсан:

Сайд	Б.Энх-Амгалан
Дэд сайд	Л.Халтар
Төрийн нарийн бичгийн дарга	С.Батболд
Төрийн захиргааны удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Б.Болор-Эрдэнэ
Бодлого, төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Э.Мөнхнасан
Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Д.Загдраднаа
Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Г.Гантулга
Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	Б.Артур
Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Д.Мягмарсүрэн
Хянасан: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	М.Энхболд
Боловсруулсан: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн	Н.Буянт